



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/39

Мандалговь

Ахмадын санд мөнгөн хөрөнгө  
төвлөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын харьяаны ахмад настнуудын нийгмийн хамгааллын асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор ахмадын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг 2024 онд батлагдсан нийт цалингийн сангийн 2 хүртэлх хувиар тооцож ахмадын санд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлсүгэй.

2. Ахмадын санд төвлөрүүлэх 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Саранзаяа)-д зөвшөөрсүгэй.

3. Ахмадын сангийн эх үүсвэр төвлөрүүлэн, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг нягтлан бодогч (Э.Саранзаяа)-д үүрэг болгосугай.



480412101